



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 517

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

БУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ БУЛГАН СУМЫН МАН-ЫН  
ХОРООНЫ ДАРГА Д.БАЗАРГҮР ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Булган сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

"Булган сумын Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Булган сумын Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт ... хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



011020609



**БУЛГАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН БАЙГУУЛЛАГААС  
2020 ОНЫ СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Булган сум




Булган сумын Монгол Ардын Намын хорооны  
2020 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн  
Тэргүүлэгчдийн хуралдааны 01 тоот  
тогтоолын хавсралт



## **АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДОРНОД АЙМГИЙН БУЛГАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

### **НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД**

- 1.1 Сумын төрийн байгууллагуудын ажилтнуудын ажиллах орчин, нийгмийн асуудлыг сайжруулахад анхаарч тогтвортой ажиллах бололцоог бүрдүүлнэ.
- 1.2 Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 1.3 Сумын төвийн ундны усны эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж тавьж, эрүүл ахуйн нөхцлийг хангасан усаар хангана.
- 1.4 Сургууль цэцэрлэгийн хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлнэ.
- 1.5 Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцах, суралцаж буй оюутан залуучуудыг дэмжиж ажиллана.



### **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 2.1 Малын үүлдвэр угсааг сайжруулж, мах сүүний чиглэлийн үхэр, хонины аж ахуйг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.2 Мал сүргийг эрүүлжүүлэх бодлогыг хэрэгжүүлж мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулна.
- 2.3 Эрүүл мэндийн төвийн өргөтгөл барина
- 2.4 Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар хийнэ
- 2.5 Хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна засвар, бохирын хоолойг шинэчлэнэ
- 2.6 Соёлын төвийн барилгыг барьж дуусгана
- 2.7 Тугийн сүмийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ
- 2.8 Сумын төвд "ГУДАМЖ" хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 2.9 Баг бүрт мал угааврын цэгүүдийн хангамжийг сайжруулна.
- 2.10 Сумын нэгдсэн халаалт, төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ..
- 2.11 Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 2.12 Мал маллах сонирхолтой залуу малчдыг дэмжиж, малжуулах
- 2.13 Сумын хэмжээнд "СУМАНДАА САЙХАН АМЬДРАЯ" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

## ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИНЫ ХҮРЭЭНД

- 3.1 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, зөв зохисто эргэлтэнд оруулж бэлчээрээ хамгаална.
- 3.2 Бүх суманд шинэ усан сан төсөл хэрэгжүүлнэ
- 3.3 Гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.4 Байгаль орчны эсрэг хууль бусаар ургамал, ан амьтан их хэмжээгээр түүж, тээвэрлэж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг таслан зогсоох
- 3.5 Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.6 Газар тариалан, төмс, хүнсний ногоо тариалалтыг дэмжиж, техник хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.

Handwritten notes in Mongolian script, possibly indicating a list of items or a signature area. The text is partially obscured by a red stamp.

БУЛГАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

2117144066  
990010595030891